

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл

Ажлын хэсгийн хуралдаан 2010 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 16 цагт Нээлттэй нийгэм форумын хурлын танхимд эхлэв.

Ажлын хэсгийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор, Багануур ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Дамбапэлжээ, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь, Инфорум төвийн тэргүүн А.Батпүрэв, Ил тод сангийн тэргүүн Д.Цэрэнжав, "Миний Монголын газар шороо" хөдөлгөөний тэргүүн Б.Болдбаатар, Монголын байгаль орчны төрийн бус байгууллагуудын нэгдсэн холбооны тэргүүн Б.Батболд, Засгийн газрын ахлах референт, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, Татварын ерөнхий газрын Тусгай хяналтын хэлтсийн дарга Я.Пүрэв, Ашигт малтмалын газрын Уул уурхайн судалгааны хэлтсийн статистик мэдээлэл, судалгааны тасгийн дарга Б.Бямбадагва, мэргэжилтэн Б.Сүхтулга, Газрын тосны газрын Хөрөнгө оруулалтын хяналтын тасгийн дарга Э.Оюун, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Уул уурхай, хүнд үйлдвэрийн бодлогын газрын орлогч дарга Ч.Цогтбаатар, Бороо гоулд ХХК-ийн татварын нягтлан бодогч Г.Лхагва-Очир, Монголын алт компанийн санхүүгийн мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, Петровичайна Дачин Тамсаг ХХК-ийн Ерөнхий захирлын зөвлөх Б.Эрдэнэдорж, Нүүрс ассоциацийн менежер Э.Сарангэрэл, Монголын ажил олгогч эздийн холбооны бизнесийн харилцааны албаны дарга Б.Жанцан нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 25 гишүүнээс 18 гишүүн оролцож, ирц 72 хувьтай байлаа.

Хуралдаанд Афганистан Улсын ОУИТБС-ын ажлын хэсгийн гишүүд, төлөөлөгчид, олон улсын байгууллагын төлөөлөгч, кино зураглаачид, Нийслэлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Адьяа, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон, санхүүгийн мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, орчуулагч Б.Ганхуяг нар урилгаар оролцов.

Ажлын хэсгийн хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор нээж, Манай ажлын хэсгийн хурлыг ямагт чухал хойшлуулашгүй асуудал гарах бүрийд хуралдуулдаг. Саяхан ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооноос манай улсын баталгаажуулалтын дүнг хэлэлцээд санаачлагыг бүрэн хэрэгжүүлэгч орноор зарласныг та бүхэн мэдэж байгаа. Шаардлагыг хангасан орон болоход мэдлэг, ур чадвараа дайчлан, идэвх санаачлагатай ажилласан ажлын хэсгийн бүх гишүүд Та бүхэнд баяр хүргэж, цаашдын хамтын ажиллагаанд улам их амжилт хүсч байна. Дашрамд, өнөөдрийн хуралд Афганистан Улсын ОУИТБС-ын ажлын хэсгийн гишүүд, ОУИТБС-ын олон улсын бага хуралд зориулан баримтат кино хийж буй найруулагч, зураглаач нар оролцож буйг та бүхэнд танилцуулахдаа таатай байна.

Өнөөдрийн ажлын хэсгийн хуралдаанаар бид 5 асуудал хэлэлцэнэ. Нэгдүгээрт, Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлан гаргах ажлын явцын тухай, хоёрдугаарт, санаачлагын хуулийн төсөл боловсруулах ажлын явцын тухай, гуравдугаарт, санаачлагын 2011 оны ажлын төлөвлөгөөний төсөл, дөрөвдүгээрт, санаачлагын нийслэлийн салбар зөвлөлийн ажлын товч танилцуулга, тавдугаарт, 2011 оны 3 дугаар сард Парис хотноо зохиогдох

ОУИТБС-ын олон улсын бага хуралд Монгол Улсаас оролцох бүрэлдэхүүнийг батлах гэсэн асуудлуудыг авч хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын дараа хурлын дотоод журмын төслийг танилцуулж, гишүүд дэмжиснээр ажлын хэсгийн хуралдаан эхлэв.

I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлан гаргах ажлын явц -Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав. /Танилцуулгыг хавсаргав/

Б.Долгор: За Цолмонгоос асуух асуулт байна уу?

Н.Дорждарь: Мэргэжлийн хяналтын байгууллага тайлан гаргаагүй компанид торгууль тавьсан гэж байна. Энэ ямар үндэслэлээр торгууль тавьсан бэ? 48.10 гэсэн заалтыг баримталсан уу, эсхүл өөр зүйл заалт байгаа юу?

Ш.Цолмон: Ашигт малтмалын тухай хуулийн 48.1-ээс 48.10-т заасан үүргээ биелүүлээгүй гэсэн үндэслэлээр 66.1-ээс 66.5 хүртэлх заалтуудад заасны дагуу зохих арга хэмжээг авсан байсан. Торгууль төлсөн 5 компани дараа нь тайлангаа нөхөж ирүүлсэн байгаа.

Б.Болдбаатар: Санаачлагын тайланд нөөц ашигласны төлбөрөө төлөөгүй нилээд хэдэн компани байсан. Энэ тохиолдолд тэдэнд ямар хариуцлага хүлээлгэх ёстой вэ?

Э.Сумъяа: Дорждарийн асуултад нэмэлт тодруулга өгөхөд Үндэсний зөвлөлийн хуралдаанаар тайлан гаргаагүй компаниудын асуудлыг хэлэлцээд мэргэжлийн хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн юм. Одоогоор шалгалт үргэлжилж байгаа бөгөөд улс орон даяар явагдаж байгаа тул нилээд удаашралтай байна. Түрүүлж шалгуулсан компаниуд зохих торгуулиа төлөөд тайлангаа нөхөж гаргаад явж байгаа. Нөөц ашигласны төлбөрөө төлөөгүй компаниудын тухайд манай тайланд хайгуулын лицензтэй компаниуд мөн адил тайлан гаргаж байгаа, гэтэл тэд нөөц ашигласны төлбөр төлөхгүй бөгөөд харин бусад татвар, төлбөр төлсөн тухайгаа тайлагнаад явж байгаа.

Б.Болдбаатар: Миний хувьд гол нь нөөц ашигласан төлбөрөө төлөөгүй компаниуд байна. Тэдгээрт ямар хариуцлага тооцох вэ? гэж асууж байгаа юм. Түүнчлэн тайлан гаргасан компаниудын талаар товч мэдээллийг бэлдсэн байна. Үүн дээр нэмээд тэдний лицензийн дугаарыг оруулах хэрэгтэй гэсэн саналтай байна.

Б.Бямбадагва: Нөөц ашигласны төлбөрийг орд ашиглаад бүтээгдэхүүн гаргасан тохиолдолд төлдөг. Уурхайн бэлтгэл ажил, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байж байгаад бэлтгэл ажил хангагдаад, хөрөнгө оруулалт хийгээд явж байгаа компаниудын хувьд нөөц ашигласны төлбөр төлөхгүй. Одоогийн байдлаар нөөц ашигласны төлбөр бүрэн төлөгдөөд явж байгаа, төлөхгүй байгаа гэсэн тохиолдол гараагүй байна.

Я.Пүрвээ: Тайлангийн нэгтгэл хийх аудитын компанийн сонгон шалгаруулах явц удааширч байна вэ? Энэ нь эхлэх хугацаанд хэр зэрэг нөлөөлөх

вэ? Хоёрдугаарт, удаашралтай байгаа нь манай зүгээс шалтгаалж байгаа зүйл байна уу?

Ш.Цолмон: Ажлын хэсэг энэ оны 7 дугаар сарын 28-нд үнэлгээний хороог байгуулсан. Анхны төлөвлөгөөгөөр шинэ оноос өмнө сонгон шалгаруулаад тайлангаа гаргаж дуусгая гэж байсан. Урьдчилсан сонгон шалгаруулалтаас Итгэлт аудит ХХК нь тендерийн бичиг баримтад тусгай зөвшөөрлийн лицензийг хавсаргаагүйн улмаас хасагдсан боловч, Итгэлт аудит гомдол гаргаж, улмаар бид Сангийн яамнаас тодруулга авах зэргээр 14 хоногийн хугацаа алдсан. Дараа нь техникийн үнэлгээний явцад Прайсуотер хаус гэдэг компани босго 80 оноогоо авч чадаагүйн улмаас хасагдсан. Бид техникийн үнэлгээний хорооны шийдвэрийг Дэлхийн банкинд 11 дүгээр сарын 5-ны өдөр хүргүүлсэн боловч одоо болтол хариу ирээгүй байна. Иймд бид Дэлхийн банкины хариуг яаравчлуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэж бодож байна. 12 дугаар сарын 15-наас өмнө Дэлхийн банкнаас хариуг авбал ирэх оны 3 сараас өмнө нэгдсэн тайлангаа гаргах төлөвлөгөөтэй байна.

Б.Долгор: За өөр асуулт, санал байна уу?

Н.Дорждарь: Ажиглаад байхад Дэлхийн банкнаас санхүүжилт ирдэг тул жилээс жилд Дэлхийн банкин дээр очоод хэд хэдэн сараар сонгон шалгаруулах ажил саатаж байдаг. Энэ жил Дэлхийн банкны уул уурхай хариуцсан мэргэжилтэн 12 дугаар сарын дундуур томилогдон ирнэ гэж байсан. Өмнө нь бас сонгон шалгаруулах ажил саатахад боломжоороо өөрийн зүгээс шахалт, шаардлагыг тавьж байсан. Энэ удаад бид Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газарт албан ёсны бичиг хүргүүлж яаравчлуулах талаар анхаарал хандуулахгүй бол ингэсээр байгаад шинэ жилийн үед аудиторуд нь ирдэг, гэтэл манай компаниуд баяр тэмдэглээд олдохгүй байх, дараа нь цагаан сар залгуулаад болох гэх мэт баяруудтай давхцаж, улмаар чанарын асуудал хүртэл яригдах вий. Иймээс албан ёсоор хандах хэрэгтэй гэсэн саналтай байна.

Б.Долгор: За ойлголоо. Энэ тал дээр анхаарал хандуулж зөвхөн Цолмонд даалгах бус Засгийн газрын зүгээс ч бас анхаарал хандуулж ажиллая.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын ОУИТБС-ын 2009 оны нэгдсэн тайлан гаргах аудитын консерциумыг сонгон шалгаруулах ажлыг шуурхайлах талаар Дэлхийн банкины холбогдох ажилтнуудтай хэлэлцэж, дүнг Ажлын хэсэгт эргэж албан шугамаар тайлагнахыг Ажлын алба (Ш.Цолмон)-нд даалгав.

II.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын явц-Хуулийн төсөл боловсруулах ажлын явцын талаар ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон танилцуулав.

Ш.Цолмон: Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2010 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 103 дугаар тушаалын дагуу энэхүү ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсэг 5 удаа хуралдсан байна. Хуулийн үзэл баримтлалыг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Эхлээд Эрдэс баялаг, эрчим хүчний яамаар хянуулж, дараа нь Сангийн яам хянаад, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн боловч яамны зүгээс үзэл баримтлалыг буцаах, дахин

боловсруулах нь зүйтэй гэсэн хариу өгсөн. Бид Хууль зүй, дотоод хэргийн яам илүү болгоомжлолтой хандаад байна уу гэж ойлгосон. Олон улсын удирдах хороо Монгол Улсыг санаачлагыг бүрэн хэрэгжүүлэгч орноор хүлээн зөвшөөрсөн үндсэн шалтгааны нэг бол яах аргагүй энэ хуулийг батлах гэж буй явдал байсан гэж бодож байна. Гэтэл одоогоор хуулийн төсөл маань буцаагдсан буюу түр саатсан байдалтай байна. Тиймээс энэ ажлыг цаашид нилээд эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Б.Долгор: Асуух асуулт байна уу?

Н.Алгаа: Бусад төрөлжсөн хуулиудтай давхардаж байна гэсэн үндэслэлээр буцаасан байсан. Бидний зүгээс цаг хугацаа хожих үүднээс хуулийн үзэл баримтлал, хуулийн төслөө хоёуланг зэрэг явуулсан нь зөв үү, буруу юу. Миний хувьд тэр давхардаж буй зүйл, заалтуудыг харъяалах хуулиудаас нь хүчингүй болгоод одоогийн энэ хуулинд оруулаад өгвөл болчихмоор санагдаад байна. Тиймээс төрөлжсөн хуулиас хасаад, энэ хуулинд оруулах гэсэн саналтай байна.

Э.Сумъяа: Хууль зүй, дотоод хэргийн яамны саналтай танилцсан. Нэг талаас яамны гаргасан санал бол үнэн байгаа юм. Бид гурван талын тэгш оролцоотой бүрэлдэхүүний харилцааг хуульчилах гээд байгаа. Гэтэл амьдрал дээр бидний харилцааг төрөлжсөн хуулиудаар зохицуулчихсан байгаа юм. Тэгэхээр миний санал бол Алгаагийн саналтай их ойрхон санал юм. Урьдаар бид ажлын хэсгийн гишүүддээ чиглэл чиглэлийнхээ мөрдөж буй хууль, дүрэм, журмыг дор бүрнээ маш сайн судлах гэсэн даалгавар өгөөд, улмаар түүнийгээ ажлын хэсгийн хурлаараа дахин ярилцаж, санал солилцох саналтай байна. Тэгээд хуулийн үзэл баримтлалаа, хуулийн төслөө мөн олон улсын практикт ямар байдаг талаар нэг дор хэлэлцээд улмаар Үндэсний зөвлөлд танилцуулж, Үндэсний зөвлөлийн зүгээс Хууль зүй, дотоод хэргийн яаманд хандвал яасан юм бэ гэсэн саналтай байна. Тэгэхдээ түрүүнд хэлсэнчлэн зарим давхардаж буй зүйл, заалт байвал энэ хуулиндаа шингээгээд, нөгөө хуулийн заалтуудыг хүчингүй болгох зэргээр нилээн цогц байдлаар ажиллавал яасан юм бэ. Тэгэхгүй бол яаравчилж байгаад хуулийн төслөө амьдралд нийцэхгүй зүйл болгочих вий гэсэн болгоомжлол байна.

Я.Пүрвээ: Нэгэнт энэ ажлын хэсэгт бүх чиглэлийн яам, агентлагууд оролцдог тул өөрсдөө ямар хууль, зүйл заалт мөрддөг, тэдгээр хуулийн зүйл заалтуудыг хэрхэн уг хуулинд давхардуулахгүйгээр суулгах талаар судалгаа хийж саяны Сумъяа гуайн хэлсэнчлэн ажлын хэсэгт танилцуулж нэгтгэж ярих байдлаар хуулийн үзэл баримтлалаа гаргавал дараа нь зөрчилгүй байх нөхцөл бүрэлдэх болов уу. Энэ талаар шийдвэрийн төсөлд тусгавал ямар вэ гэсэн саналтай байна.

Б.Жанцан: Тусад нь бие даасан хууль гаргавал төвөгтэй байж болох юм. Тиймээс холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулвал яасан юм бэ? Хоёрдугаарт, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулах шийдвэрийг ганц яамны сайдын бус, 2-3 сайдын хамтарсан тушаалаар шийдвэр гаргах хэрэгтэй. Тэгж байж бие биенийхээ үйл ажиллагааг дэмжих байх. Шадар сайд юмуу Ерөнхий сайдын хэмжээнд энэ асуудлыг аваачих нь илүү үр дүнтэй байх гэж бодож байна.

Б.Долгор: Уул нь шийдвэрийн төсөлд ажлын хэсгийн гишүүдэд хуулийн төслийг хүргүүлж санал аваад, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж, Үндэсний зөвлөлд танилцуулья гэсэн байсан. Тэгэхээр хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг дахин шинээр байгуулах нь зөв санагдаж байна. Ерөнхий сайд юмуу Шадар сайдын хэмжээнд шийдвэрлэхээр, яам, яамдын төлөөлөл орсон буюу арай өндөр хэмжээнд ажлын хэсгийг байгуулан ажиллах нь илүү үр дүнтэй байж болох юм. Түрүүний хэлснээр тухайн мөрдөгдөж буй хуулийн холбогдох яам, агентлаг, газруудын хүмүүсийг оролцуулж хуулийн төслийг дахин боловсруулах, харин дахин боловсруулахдаа хуулийн төсөл нь нэгдсэн хууль байх уу, эсхүл Жанцан гуайн хэлснээр холбогдох хуулиудад нь нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл байх уу гэдгийг дахин авч үзэх хэрэгтэй. Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөллийг оруулья, хуулийнхаа төслийг Үндэсний зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлэх замаар энэ шат үргэлжлэх нь зүйтэй гэж үзэж байна. Ийм маягаар шийдвэрээ томъёолоод явья гэсэн саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаатай холбогдуулан ажлын хэсгийн холбогдох гишүүд төрөлжсөн хуулиудыг судалж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахыг ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонд даалгав.

2. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг дахин шинээр байгуулахыг Үндэсний зөвлөлд зөвлөмж болгов.

3. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг дахин боловсруулж, Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэхийг хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт үүрэг болгохоор тогтов.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын 2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл-Э.Сумъяа: Санаачлагын хүрээнд хэрэгжүүлэх 2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний товч танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Энэ төлөвлөгөөг боловсруулахдаа дараахи үндсэн зарчмуудыг баримталсан. Нэгдүгээрт, нэгэнт бид 4 жил дараалан төлөвлөгөөтэй ажиллаж ирсэн бөгөөд өмнөх төлөвлөгөөнүүдийн ололт, туршлагад тулгуурласан; хоёрдугаарт, ОУИТБС-ын Олон улсын удирдах хорооноос баталгаажуулалтын явцад болон түүний дараа өгсөн анхааруулга, зөвлөмжийг тусгасан; гуравдугаарт, Үндэсний зөвлөл болон ажлын хэсгээс гаргасан өмнөх шийдвэрүүдэд 2011 онд хэрэгжүүлэхээр заасан асуудлуудыг мөн тусгаж өгсөн. Холбогдох зардлуудын нарийвчилсан дүнг тавиагүй байгаа бөгөөд санхүүжилтыг гурван эх үүсвэрээс авахаар төлөвлөсөн. Үүнд: нэгдүгээрт, 2011 оны улсын төсөвт 247,6 сая төгрөгийг тусгасан боловч батлагдсан эсэх нь мэдэгдээгүй байна. Энэхүү эх үүсвэрээс Монгол Улсын нэгдсэн тайлан гаргах, төрийн нэрийн өмнөөс ажил, үйлчилгээ хэрэгжүүлэх, шагнал урамшуулал олгох гэсэн зардлуудыг санхүүжүүлнэ. Хоёрдугаарт, чадавхи бэхжүүлэх чиглэлээр Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй хамтран ажиллах талаар хэлэлцээр хийгээд явж байна. Энэхүү эх үүсвэрээс сургалтын зардал, хуулийн зөвлөгөө өгөх зардал гэх мэтээр нилээд хэдэн ажлуудыг санхүүжүүлэхээр тусгасан байгаа. Гуравдугаарт Дэлхийн банкны итгэлийн сангаас ажлын албаны зардлыг үргэлжлүүлэн авах саналыг тавьсан

байгаа. 2011 оны төлөвлөгөөний гол онцлог бол чадавхи бэхжүүлэх, мэдээлэл түгээх тал дээр нилээд анхаарсан байгаа. Мөн хамтын ажиллагааны талаар энэ жил тусад нь бүлэг болгон оруулсан байгаа. Нэгэнт төлөвлөгөөг тараасан тул би нэгбүрчилэн ярихгүйгээр та бүхнээс санал аваад цаашид Үндэсний зөвлөлд танилцуулан батлуулах юм.

Б.Долгор: Асуулт байна уу?

А.Батпүрэв: Түрүүнд компаниуд тайлангаа гаргахгүй байна гэж ярьж байсан. Тэгэхээр тайлангаа гаргахгүй байгаа компаниудтай хэрхэн ажиллах, ямар арга хэмжээ авахаар төлөвлөсөн байгаа вэ?

Э.Сумъяа: Энэ талаар 2009, 2010 оны тайлан гаргах гэсэн дөрөвдүгээр бүлгийн 27-33 дугаар хэсэгт тусгасан байгаа. Тухайлбал, компаниудын төлөөллийг оролцуулах замаар хүмүүстэй ажиллах, хоёрдугаарт, чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Энд бид юунд зорьсон гэвэл бид компаниудыг тайлан албадан гаргуулахдаа бус, сургалт зохион байгуулсны үр дүнд санаачилгын зорилгыг ойлгуулах, түүнд идэвхтэй оролцуулах, тайлангаа хугацаандаа гаргадаг болгох талаас нь асуудалд хандая гэсэн юм. Нөгөө талаар ажлын алба өөрийн өдөр тутмын төлөвлөгөөтэй явдаг. Тэгэхээр ажлын алба ямар компанитай харилцах, хандах талаараа төлөвлөөд, ажиллаад явна гэж ойлгож байгаа.

Ш.Цолмон: Компаниудыг хамруулах чиглэлээр Ажлын алба урьдын адил сургалт, бага хурал зохион байгуулж ажиллахаас гадна Ашигт малтмалын газар дээр ОУИТБС-ыг хариуцсан орон тооны хүн ажилладаг болсон байгаа. Мөн газрын тосны газартай хамтран газрын тосны компаниудыг хамарсан сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Он гараад эдгээр ажлууд маань хэрэгжээд явна.

Ж.Жанцан: Бүтээгдэхүүн хуваах гэрээний ил тод байдлыг хангах эрх зүйн орчны талаар судлах гэсэн байна. Одоо бол газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэгдээд явж байгаа байх. Тэрнээс гадна саяын ярьсан ОУИТБ-ын хуулийн төсөл боловсруулагдаад явж байна. Тэгэхээр энэ хоёр хуулийн алинаар нь зохицуулалт хийх вэ? Түрүүний нэгдсэн хууль гарчих юм бол энэ хуулиндаа хамрагдаад явахгүй юмуу? Эрх зүйн орчинг судлах гэж яг юуг хэлээд байна вэ?

Э.Сумъяа: Энэ бол ОУИТБС-ын дунд хугацааны стратегид тусгагдсан асуудал байна. Одоо бол бүтээгдэхүүн хуваах гэрээ маань байгууллагын нууцын зэрэглэлд явдаг юм билээ. Бид Газрын тосны газрын удирдлагатай санал солилцохдоо Засгийн газар болон компанийн бүтээгдэхүүн хуваах хувийг зарлахгүйгээр бусдыг ил тод болгох хувилбараар ярилцсан. Үүнийг эрх зүйн орчин гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл байгууллагын нууцын зэрэглэлээс алийг нь гаргах вэ гэдгийг тохиролцох асуудал л даа. Одоогийн байдлаар ингэж зохицуулах боломж байгаа. Учир нь бүтээгдэхүүн хуваах хувь хэмжээ маань газар зүй, геологийн онцлогоос шалтгаалаад талбай бүрд өөр өөр байдаг юм байна. Тийм болохоор компаниуд хоорондоо барьцах гэх зэрэг хүндрэлтэй зүйлүүд гардаг юм байна.

Б.Бямбадагва: Ер нь маягтаар мэдээлэл авах тал дээр 2009 онд онцгой анхаарч ажилласан. Ялангуяа Ашигт малтмалын газрын зүгээс ОУИТБС-ын маягтыг бөглөж өгөөгүй тохиолдолд тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллана гэдэг шахалтаар өмнө нь байгаагүйгээр нилээд их компаниудаас тайлан гаргуулж авсан. Манай мэргэжилтэн Сүхтулга бол одоогоор орон тооны бус, гэрээгээр ажиллаж байгаа. Орон тооны болгох талаар дэмжлэг үзүүлнэ үү. Энэ ажлыг зайлшгүй нэг хүний орон тоогоор ажиллахгүй бол бусад ажилтай давхар хийх тохиолдолд өөрсдийн бусад ажилдаа дарагдаад энэ санаачлагын ажил орхигдох байдал ажиглагддаг.

Өмнө нь зохион байгуулагдаж байгаагүй бүс бүсийн уулзалтуудыг төлөвлөсөн байна. Энэ ямар учиртай уулзалт вэ?

Ш.Цолмон: Өвөрхангай, Сэлэнгэ гэх зэрэг аймгуудад бүсийн чуулган болж байсан. Энэ онд хэд хэдэн ийм уулзалтыг төлөвлөсөн байсан боловч баталгаажуулалтын ажил давхцаад, мөн төсөв мөнгөний асуудал хүрэлцэхгүй хойшлогдсон байгаа. Бүсийн уулзалт гэдэг маань бүсчилээд тухайн бүсийн уул уурхайн компаниуд, төрийн бус байгууллага, салбар зөвлөлийн багууд ирээд ОУИТБС-ын бүсийн түвшинд ямар ажил хийж болох вэ, юуг анхаарах гэх мэтээр олон нийтийн хэлэлцүүлэг хийх, санал бодлоо хуваалцах нь чухал ач холбогдолтой байдаг. Орон нутгийн уулзалтын үеэр байгаль орчны мөн гар аргаар олборлогчдын гэх зэрэг хүнд хүнд асуудлууд сөхөгддөг. Гэхдээ бид үүнийг бас хамтран харилцан ярилцаж санал бодлоо хуваалцах нь чухал байдаг.

Б.Батболд: Нэг зүйл тодруулья. Би шинээр ажлын хэсэгт орж ирж байгаа болохоор тодруулах зүйлс гараад байна. Итгэлийн сан гэж хаанаас гарч ирдэг мөнгө вэ? 2011 оны төлөвлөгөө гэж ярьж байгаа боловч дотор нь 2010 оны 2 дугаар сар гэсэн байна. Энэ хийгдсэн ажил юмуу, эсхүл хийгдэх гэж байгаа юмуу? 2007, 2008, 2009 оны тайлан, хураангуйг хэвлүүлнэ гэсэн байна. Энэ нь тайлан, хураангуй гээд 2 юм гаргах гээд байгаа юмуу? Тус тусад нь мөнгө төсөвлөсөн байна, гэхдээ үүнийг зардал хэмнэх үүднээс нэгтгээд нэг гаргаж болдоггүй юмуу?

Ш.Цолмон: 2010 оны 2, 6 дугаар сар гэдэг техникийн алдаа байна. Хүлцэл өчье. Итгэлийн сангийн хувьд ОУИТБС маань олон улсын санаачлага. Иймээс энэхүү санаачилгыг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Европын хэд хэдэн улсууд нийлж Дэлхийн банкин дээр Итгэлцлийн санг байгуулсан юм. Харин захиран зарцуулах заавар журам нь Дэлхийн банкны журмаар явдаг. ОУИТБС-ын нэгдсэн тайлан нь нилээд дэлгэрэнгүй зузаан тайлан гардаг. Гэтэл сүүлийн жилүүдэд энэхүү тайланг уншихад хүндрэлтэй, их дэлгэрэнгүй байна гэсэн санал шүүмжлэлүүд ирж байгаа тул дэлгэрэнгүй тайлангаа илүү товчилсон, олон нийт уншихад ойлгомжтой, товчхон байдлаар хураангуй хувилбарыг гаргая гэж зорьж байна.

Б.Долгор: Өөр асуулт байна уу? Байхгүй бол саналаа хэлэе.

А.Батпүрэв: Урьд нь сонин дээр нилээд том хүснэгт хэвлэж байсан, мөн дэлгэрэнгүй тайланг хэвлүүлж байсан. Гэхдээ үр дүнг нь нэмэгдүүлэхийн тулд энгийн иргэдэд илүү ойлгомжтой байдлаар, өмнөх онуудтай харьцуулсан байдлаар тухайлбал 2006-2009 оны тайлангуудыг нэгтгээд нэг гарын авлага хийх нь зүйтэй гэсэн саналтай байна. Мэдээллийг нэг дор харьцуулсан байдлаар өгөх

нь олон нийтэд илүү хүрэх байх гэж бодож байна. За бас нэг санал бол хэдийгээр санаачлагын оролцогч талуудын хамтын ажиллагаа, идэвх зүтгэлийн үр дүнд Монгол Улс санаачилгыг хэрэгжүүлэгч орон болсон, мөн тайлан гаргагч компаниудын тоо нэмэгдэж байна гэх зэрэг эерэг талууд байгаа боловч тайлан гаргах цаг хугацааны хувьд нилээд хоцрогдож явж байна. 2009 оны тайланг 2011 онд аудит хийлгээд 2011 оны дундуур олон нийтэд мэдээлэх нь учир дутагдалтай болоод байна. Хэдийгээр энэ хоцрогдол нь Дэлхийн банкны хариуг хүлээх, сонгон шалгаруулах явцаас болж байна гэх боловч үүнийг төлөвлөж болох хугацаа гэж бодож байна. Хугацааг хойш татаж буй хамгийн гол зүйл бол дараа оны 9 сар болтол буюу бүтэн жилийн турш тайланг цуглуулдаг явдал байгаа юм. Тэгэхээр миний хувьд жилийн жилд ингэж төлөвлөөд бодит байдал дээр сунжирдаг тул яг хугацаанд нь тайланг гаргуулахын тулд ямар ажил хийх вэ гэдэг төлөвлөгөөг илүү нарийн дэлгэрэнгүй оруулмаар байна. 1 дүгээр сард нь хуулийн зүйл заалтуудыг сурталчилж, 2 дугаар сард сургалтуудаа зохион байгуулах гэх мэтээр төлөвлөгөөнд нилээд тодорхой тусгах саналтай байна. За дараа нь жил жилийн тайланд шийдэгдээгүй зөрүү гардаг. Тэгэхээр Монгол Улс өөрөө санаачлагыг бүрэн хэрэгжүүлэгч орны хувьд мөн 4 дэх жилийн тайлан гаргаж байгаа орны хувьд одоо тэр шийдэгдээгүй зөрүүг тодорхой болгох чиглэлээр илүү бодитой ажил хийвэл яасан юм бэ гэсэн саналтай байна.

Д.Дамбапэлжээ: Бүсийн уулзалт семинаруудад болж өгвөл тухайн орон нутагт олборлох үйлдвэрлэл эрхэлж буй компаниудын захирлуудыг оруулж байх нь зүйтэй. Хоёрдугаарт, иймэрхүү семинаруудад аль болох олон компанийг оролцуулж, сургалт семинар дээр тайлан гаргах аргачлалыг заахаасаа илүү ОУИТБС-ын ач холбогдолыг сурталчилах нь илүү ач холбогдолтой гэж бодож байна. Компанийн захирлууд ойлгохдоо Сангийн яам, татварт өгдөгтэй адилхан бас нэг тайланг гаргаж өгөөд байна гэж ташаа ойлголттой явдаг. Тиймээс тэдгээр компаниудын захирлуудад ОУИТБС-ын тайлан нь дээрх тайлангуудаас ямар ялгаатай, ач холбогдол нь юу байх, энэхүү тайланг гаргаснаар ямар ашиг тустай гэдгийг илүү ойлгуулах, сурталчилах хэрэгтэй байна. Бүсийн зөвлөгөөн яг уул уурхайн ажил идэвхждэг улиралд зохион байгуулагдахаар тавигдсан байна. Иймд хугацааг нь дахин нэг харах байх гэсэн саналтай байна.

Н.Дорждарь: Цаашид баримтлах бодлого, зохион байгуулалтын хүрээнд гэдэг дээр эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах бодлого хэлэлцэж, батлагдах магадлалтай байгаа. Тэгэхээр төрөөс баримтлах бодлогод санаачлагын тухай тусгуулах талаар онцгой анхаарах, мөн бусад санаачлагуудтай ялангуяа компанийн засаглалын хүрээнд, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэж буй санаачлагуудтай бодлогоо уялдуулах нь олон нийтэд хүргэхэд илүү тус дөхөмтэй юм болов уу. Тайлангийн маягт зааврыг эцэслэн найруулж гэдэг дээр олон салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн хувьд зөвхөн уул уурхайгаас олсон орлого нь тавигдсан байна уу гэдгийг яаж нягтлах вэ? энэ талаар онцгой анхаарч ажиллах ёстой юм болов уу. 2010 оны тайланг 2011 оны 10 сард гаргахаар төлөвлөсөн байна. Гэхдээ энэ хугацааг наашлуулах хэрэгтэй. Дараа жил бид улсын төсвөөс аудитын үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлэх бол Дэлхийн банкаар дамжих шаардлагагүй болно. Тэгэхээр төсөв нэгэнт батлагдсан бол бид ажлаа өнөөдрөөс эхлээд зохион байгуулах бололцоо байна, энэ мэтээр бид хугацааг наашлуулах талаар онцгой анхаарч ажиллахгүй бол 2 жилийн дараа гардаг энэ хүрээнээс гарч чадахгүй яваад байна. Чадавхийг бэхжүүлэх дээр хэдийгээр тайлан гаргах компаниудийн

чадавхийг бэхжүүлэх шаардлагатай байгаа боловч иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх явдал дутмаг байгаа юм. Иргэний нийгмийн байгууллагуудын хувьд жишээлбэл манай байгууллагын хувьд өөрийнхөө чадлаар үүнийг хийх гэж оролдож байна. Гэхдээ Үндэсний зөвлөл, ажлын хэсэг энэ талаар анхаарлаа хандуулж ажиллах нь чухал гэж үзэж байна.

Я.Пүрвээ: Чадавхийг бэхжүүлэх, сургалт зохион байгуулах хүрээнд гэсэн хэсгийн 35 дахь хэсгийг дахин нэг харах. Хуулиндаа бол Сангийн яам нэгтгэлийг хийнэ гэж заасан байдаг. Тиймээс Засгийн газрын тайлан гаргадаг төрийн захиргааны байгууллагуудын төлөөлөл байгуулна гэж үзвэл Сангийн яамны дэргэд байгуулах нь илүү бодитой гэсэн саналтай байна.

Б.Долгор: За өөр санал хэлэх хүн байна уу? За гишүүд маань их чухал чухал санал дэвшүүллээ. Ялангуяа бид тайлан гаргаж нэгтгэх, түүнийхээ үр дүнг олон нийтэд мэдээлэх хугацааг зайлшгүй наашлуулах шаардлагатай. Энэ асуудлаар онцгой анхаарлаа хандуулах ёстой бөгөөд энэ талаар 2011 оны төлөвлөгөөнд ямар нэгэн байдлаар тусгаж, биелүүлэхийн тулд хичээж ажиллах нь зүйн хэрэг гэж бодож байна. Нөгөө талаас тайлангийн ач холбогдлыг нийтэд илүүтэй сурталчлах, тухайн компанид сурталчлах тал дээр бид их анхаармаар байна. Маш их ажил болж тайлан гаргадаг, нэгтгэдэг тэр маань төдийлөн олон нийтэд хүрч чадахгүй байна. Иймээс хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтэд хүргэх мэдээлэлд их анхаарч ажиллах ёстой. Яг энэ ажлын хүрээнд 2011 оны төлөвлөгөөнд 63, 64 дэх хэсэгт улиралд нэг удаа хэвлэл мэдээллийн байгууллагуудтай уулзалт, ярилцлага хийх гэсэн байна. Тэгэхээр ийм байж болохгүй юм. Энэ байгууллагын үйл ажиллагааны эцсийн зорилго бол нийтэд мэдээлэх явдал юм. Тухайлбал уул уурхайн компаниуд төлөх, нөгөө талаас төр засаг авах энэ үйл ажиллагаа нь шударга зөв явагдаж байна уу гэдгийг тодруулж, ийм байна гэдгийг олон нийтэд мэдээлэх явдал юм. Уул уурхайн компаниуд маань ч, иргэний нийгмийн байгууллагууд маань ч өөрсдийн зүгээс хүчин чармайлт гаргаж, хүсэл эрмэлзлэлээ илэрхийлж байх ёстой. Гэтэл ингэхгүй байгаагаас гурван тал маань гурван талд гарч суух нөхцөл байдал өнөөдөр ч гэсэн байсаар байна. Хэдийгээр бид гурван талыг нэгтгэж, зохион байгуулж энэ үйл ажиллагааг явуулж байгаа ч гэсэн ялангуяа манай иргэний нийгмийн зарим байгууллагууд санаачлагынхаа үйл ажиллагаанд төдийлөн оролцохгүй хэрнээ гудамжинд гарч асуудлыг ярих жишээтэй. Бидний зорилго бол энэ биш шүү дээ. Энэ байгууллагынхаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцоод хийх шаардлагатай зүйлсийг энэ байгууллагаараа дамжуулан хийж чадах юм бол илүү үр дүнд хүрч чадна. Тийм учраас хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, компанийн болон иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэх тал дээр онцгой анхаарал хандуулан ажиллая. Төлөвлөгөөнд энэ талаар тусгасан асуудлуудыг илүү нарийвчлала. Хэлсэн саналуудыг бүрэн дэмжиж байна. Бас нэг чухал зүйл бол төр засгийн бодлого шийдвэрийг боловсруулах болон хэрэгжүүлэх ажилд манай санаачлагын байгууллагын оролцоо илүү тод байх ёстой. Яамд, агентлагууд хэдийгээр ажиллаж байгаа ч гэсэн санаачлагынхаа чиглэлээр хийгдэх ажлууд дээр ажиллая. Бусад санаачлагуудтай мэдээж хамтарч ажиллаж байж илүү үр дүнд хүрэх ёстой. Жишээлбэл, Хариуцлагатай уул уурхай гэсэн төрийн бус байгууллага байдаг. Энэ байгууллагатай манай санаачлага төдийлөн нягт хамтран ажиллаагүй юм шиг санагддаг. Энэ мэтчилэн нэг зорилготой байгууллуудтай нягт хамтран ажиллая.

За бусад саналуудыг хүлээн авья. Тайлангийн хэвлэлт дээр үнэхээр гишүүдийн саналыг хүлээж авах ёстой. 2007 оны тайланг яг тэр хэвээр нь хэвлэх нь ач холбогдол багатай. Нарийн дэлгэрэнгүй тайланг вэбсайтад байршуулах, хэвлэх тайланг хялбаршуулж гаргамаар байна. Хамгийн сүүлийн тайланг илүү хэрэглээ талруугаа гаргуулсан. Хүмүүс хэрэглэх боломжтой байх тэр талруу нь анхаарая. Зарим нэг зардал шаардсан зүйл дээр тухайлбал орон тооны хүн гаргах гэх мэт зүйлүүд дээр зардал байна уу гэдгийг нарийвчлая. Зардалгүйгээр хийх Засгийн газрын шугамаар үүрэг өгч хийлгэх боломжтой ажлуудыг мөн бас ялгаж салгая. Зардлыг нарийвчилж гаргая. Тэгэхээр саяны гишүүдийн хэлсэн саналыг мөн миний хэлсэн санал, тодруулгуудыг тусгаад 2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ажлын хэсгийн зүгээс сайшаах уу?

Н.Алгаа: Сурталчилгааны ач холбогдол их өндөр байна. Харин хэвлэн нийтлэх, сурталчлах зардал их өндөр байна. Иймээс 2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаснаас гадна ОУИТБС-ыг сурталчилах хөтөлбөрийг тусад нь боловсруулж олон улсын байгууллагуудад санал тавих, тэдний зүгээс ч бас дэмжих боломжтой гэж үзэж байна.

Б.Долгор: Тийм энэ их зөв санал. За төлөвлөгөөгөө сайшаах уу? За дараагийн асуудалдаа орье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.ОУИТБС-ын 2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийн талаар ажлын хэсгийн гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналуудыг нэгтгэн судалж, төлөвлөгөөнд тусган Үндэсний зөвлөлд оруулж батлуулахыг Ажлын хэсгийн ахлагч Б.Долгор, Ажлын алба (Ш.Цолмон) -д даалгав.

2.2011 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Үндэсний зөвлөлөөр батлагдах хүртэл хугацаанд Ажлын хэсэг, Ажлын алба даган мөрдөж ажиллахаар тогтов.

Ү.ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын Нийслэлийн салбар зөвлөлийн ажлын товч танилцуулга-Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Адъяа танилцуулав.

Б.Адъяа: Нийслэлийн Засаг даргын 86 дугаар тушаалын дагуу ОУИТБС-ыг дэмжих нийслэлийн зөвлөл байгуулагдсан. Зөвлөлийн даргаар Засаг даргын орлогч Д.Ганболд ажилладаг. Салбар зөвлөл нь төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөлөлтэй нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Салбар зөвлөлийн гишүүд нийслэлийн мэргэжлийн хяналтын байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай хамтран 2010 оны 5 дугаар сард нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүд, асфальт болон хайрга бутлан ангилах үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн. Шалгалтын явцад нийт нийслэлийн нутаг дэвсгэрт олборлох үйлдвэрлэлтэй холбоотой 253 аж ахуйн нэгж ажилладаг юм байна, үүнээс хайгуулын зөвшөөрөлтэй нь 110, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нь 143 байна. Шалгалтын явцад ОУИТБС-ын тайланг хэрхэн гаргаж байгаа талаар үзэж, нягталсан. Мөн тайлангаа гаргахад зөвлөгөө өгч ажилласан. Мөн нийслэлийн салбар зөвлөлөөс ОУИТБС-тай холбогдон гарсан баримтат киног UBS телевизээр дамжуулан сурталчилж, мэдээлэх ажлуудыг

хийсэн. Ажлын албанаас зохион байгуулсан сургалт семинарт оролцож, тайланг хэрхэн гаргах талаар аж ахуйн нэгжүүддээ мэдээлж ажиллалаа.

Б.Долгор: Асуух асуулт байна уу?

Я.Пүрэв: Дүүргүүдэд салбар зөвлөл гэж байх уу?

Б.Адъяа: Дүүргүүдэд одоохондоо байхгүй. Ашигт малтмалын аж ахуйн нэгж олонтой Багануур, Налайх гэх мэт дүүргийн Засаг дарга нарыг нийслэлийн салбар зөвлөлд оруулсан байдаг.

Ш.Цолмон: Салбар зөвлөл байгуулагдаад удаагүй байна. Нийслэл маань өөрөө их ачаалалтай байгууллага. Нилээн олон дутагдалыг илрүүлсэн байгаа. 2009 оны тайлан гаргах ажил дээр хамтарч ажилласан. Нийслэлийн салбар зөвлөлтэй цаашид нягт хамтарч ажиллах тул ажлын хэсгийн гишүүддээ мэдээлэл өгөх зорилгоор өнөөдөр урьж оролцуулсан. Аймгуудад салбар зөвлөл байдаг. Та бүхнийг салбар зөвлөлийн талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй болсон байх гэж найдаж байна.

Б.Долгор: Санал байна уу?

Э.Сумъяа: Нийслэлийн болон аймаг орон нутгийн салбар зөвлөл нь бидний харилцаа холбооны гол тулгуур болох юм. Тийм учраас ажлын хэсэг, ажлын албаны зүгээс салбар зөвлөлүүдээ дэмжиж, ялангуяа арга зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай байдаг. Адъяад талархаж байна. Энэ үйл ажиллагааг цаашид аймгуудад сурталчлах, дараачийн хурлаар аймгийн салбар зөвлөлийн тайланг сонсох гэх мэт үйл ажиллагаагаа улам өргөжүүлэх хэрэгтэй байна.

Н.Дорждарь: Мэдээллийн чанартай дурьдахад Нээлттэй нийгэм форумаас "Орлогын ажиглагч" гэсэн гадаадын байгууллагатай хамтраад ил тод байдлын тайланг сумын түвшинд гаргавал ямар байх нь гэсэн туршилт явагдаж байна. Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдад эхний удаа туршилтаа явуулж байна. Ханбогд, Гурвантэс суманд ОУИТБС-ын сумын гурван талын оролцоотой ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Санаа нь бол ОУИТБС-ын тайланг сумын түвшинд гаргаад олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэх байдлаар туршилт хийж үзэж байна. Өөрөөр хэлбэл олон нийтэд хүргэх ажлыг яг уул уурхайн олборлолт идэвхтэй хийгдэж буй уг сумын иргэдээс эхлэх нь чухал юмуу гэж бодож байна.

Б.Жанцан: Аймаг, хотуудад салбар зөвлөл байгуулах нь ач холбогдолтой санагдаж байна. Зарим нэг зүйлийг тодруулах шаардлагатай байна. Тухайлбал Улаанбаатарт толгой компани нь байдаг, аймаг суманд үйлдвэр нь байдаг компанийн хувьд аль салбар зөвлөлтэйгээ илүү ажиллах вэ? Түүнчлэн элс, хайрганы жижиг компаниуд ил тод байдлын тайлан гаргах шаардлага байна уу? Салбар зөвлөл нь ил тод байдлын санаачлагын ажлыг байгаль хамгаалахад чиглэсэн болон бусад хяналт шалгалтын ажилтай холихгүй байх, ингэж ажилласнаас үүдэж ил тод байдлын санаачлагын нэр хүнд унаж болзошгүй юм. Ажлын хэсэг салбар зөвлөлдөө маш сайн зөвлөгөө өгч ажиллах хэрэгтэй гэсэн саналтай байна.

Б.Долгор: За гишүүдийн гаргасан саналыг анхаарч тусгая. Нийслэлийн салбар зөвлөлд тогтмол дэмжлэг үзүүлж ажиллах, нийслэлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг аймгийн салбар зөвлөлд хүргүүлэх, зөвхөн нийслэлийн бус аймгуудын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, тэдэнд зохион байгуулалтын болон арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх гэсэн ийм асуудлуудыг нэмж тусгаж өгье. Түүнчлэн онцгой анхаарал татаж буй аймгуудад тухайлбал Өмнөговь гэх мэт аймгуудад илүү анхаарал хандуулан ажиллах шаардлагатай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Нийслэлийн салбар зөвлөлөөс 2011 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Ажлын алба (Ш.Цолмон)-д даалгав.

2. Нийслэлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны мэдээллийг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцсэн тухай мэдээллийг аймгуудын салбар зөвлөлд мэдээлэх, аймгуудын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд арга зүйн туслалцаа үзүүлэхийг Ажлын алба /Ш.Цолмон/-нд даалгав.

3. Өмнөговь зэрэг уул уурхайн үйлдвэрлэл төвлөрч байгаа аймгийн салбар зөвлөлийн ажилд газар дээр нь аргачилсан зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэхийг Ажлын алба /Ш.Цолмон/-нд даалгав.

Ү. ХЭЛЭЛЦСЭН нь: 2011 оны 3 дугаар сард Парис хотноо зохиогдох олон улсын бага хуралд оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүний тухай- Ш.Цолмон танилцуулав. Ш.Цолмон: ОУИТБС-ын олон улсын бага хурал нь хамгийн дээд удирдах байгууллага юм. 2 жилд нэг удаа хуралддаг. 5 дугаар бага хурал Парис хотноо болох гэж байна. Парисын бага хуралд манай улс нь стандартыг хангасан улс болсон гэдгээрээ олны анхаарлын төвд байгаа бөгөөд Монгол Улсын нэр хүнд сайн байгаад хувьдаа олзуурхаж байна. Дохагийн бага хуралд явсан бүрэлдэхүүнтэй харьцуулан Парисын бага хуралд оролцох бүрэлдэхүүнийг санал болгов. Зохион байгуулагчийн зүгээс 4 хүний зардлыг даахаар мэдэгдсэн. Үлдсэн 4-5 хүн өөрийн байгууллагаас зардалаа даагаад оролцох байх. /Товч танилцуулгыг хавсаргав/.

Б.Долгор: Асуулт байна уу?

Б.Батболд: Иргэний нийгмийн байгууллага гэхээр л Нээлттэй нийгэм форум гэж ойлгодог бололтой. Дохагийн бага хуралд 2 хүн явсан байна, одоо бас Парисын бага хуралд 2 хүн байх жишээтэй. Өөр байгууллага байгаа шүү дээ. Тэднийг оролцуулах боломжгүй юмуу? Санхүүжилтын ямар боломж бололцоо байна?

Ш.Цолмон: иргэний нийгмээс 1, төр засгаас 1, компаниас 1, ажлын албаны 1 гээд нийт 4 хүний зардлыг цаанаас хариуцахаар чиглэл өгсөн.

Н.Дорждарь: Тодруулга өгье. Миний хувьд би өөрөө олон улсын удирдах хорооны гишүүн учраас миний зардлыг цаанаас даах байх. Өөрөөр хэлбэл Монгол Улсаас 5 хүний зардлыг даах бололцоотой. Иргэний нийгмийн байгууллага гэхээр дандаа нээлттэй нийгэм форум яваад байдаг гэж байна. Нэг талаас ингэж шүүмжлэх нь зөв юм. Манай байгууллагын хувьд өөрөө энэ

санаачлагад маш идэвхтэй оролцдог тул нэрээ дэвшүүлдэг. Гэхдээ бид энэ удаад зардалаа өөрсдөө даахаа үүгээр мэдэгдэж байна. Харин зохион байгуулагчийн зардлаар явах иргэний нийгмийн байгууллагыг дундаасаа сонгон шалгаруулах маягаар тодруулах нь зөв байх. Өөр байгууллага нэрээ дэвшүүлэх бүрэн бололцоотой, нээлттэй шүү. Ер нь иргэний нийгмээс гадна компаниудыг өөрсдийн бололцоогоор зардалаа даагаад идэвхтэй оролцохыг миний зүгээс уриалмаар байна. Засгийг төлөөлүүлж татварын байгууллагаас оролцуулах нь зөв юмуу гэсэн саналтай байна.

Н.Алгаа: Цолмон зардалаа өөрсдөө даагаад яваарай гэсэн учраас би зардалаа гишүүн компаниудаас гаргуулахаар төлөвлөж байгаа. Гэхдээ Үндэсний зөвлөл болон ажлын хэсгийн гишүүн компаниуддаа санал тавьж бид өөрсдөө бололцооныхоо хэрээр санхүүжилтээ шийдээд энэ хуралд оролцох бололцоо байгаа болов уу гэж бодож байна.

Б.Цогтбаатар: Парисын бага хуралд Монгол Улсын ОУИТБС-д идэвхтэй оролцдог хүмүүсээ зардлыг нь зохион байгуулагчаар даалгуулаад явуулах нь зүйтэй гэж бодож байна. Ашигт малтмалын газраас 1 хүнээ оролцуулах хэрэгтэй гэж бодож байна.

Б.Бямбадагва: Сүхтулга мэргэжилтнээ явуулая, зардлыг нь боломжоороо байгууллагаас гаргая.

Б.Болдбаатар: Миний монголын газар шороо хөдөлгөөний хувьд бидний зардлыг даавал оролцоно.

Н.Дорждарь: Саналаа хэлэхэд Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирын зардлыг зохион байгуулагчаас даах гэдэгт оруулж өгнө үү, харин бид өөр нэг иргэний нийгмийн байгууллагын зардлыг санхүүжүүлэе

Б.Батболд: Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 500 гаруй иргэний нийгмийн байгууллага байна. Үүнээс хэн нь явах асуудлыг иргэний зөвлөлд нээлттэй орхиод бид дотроосоо шалгаруулаад нэрээ өгөх саналтай байна.

Б.Долгор: Санаачлагын гишүүн иргэний нийгмийн байгууллагаас сонгож явуулах нь зүйтэй байх. Ер нь бол хэр идэвхтэй ажилласан байдлыг харгалзаад шийдээд явуулах нь зүйтэй. Ийм ямар байгууллага байгааг өнөөдөр шууд хэлэх бололцоо байна уу, эсхүл дараа нь тодруулах уу?

Э.Сумъяа: Ажлын хэсэгт иргэний зөвлөлийн 8 байгууллага, Үндэсний зөвлөлд 3 байгууллага байдаг. Гэхдээ иргэний нийгмийн 1 хүний зардлыг даагаад хуралд оролцуулах боломж байна, ямар хүнээ явуулахаа иргэний нийгэм өөрсдөө дотроо шийдэх хэрэгтэй байх, хоёрдугаарт, Зоригт сайд миний нэрийг дэвшүүлсэнд талархлаа илэрхийлж байна, гэхдээ зардал мөнгөний асуудал хүнд байвал миний хувьд явахгүй байх боломжтой гэдгээ хэлье. Энэ удаагийн хурлын онцлог бол манай Монгол Улс санаачилгыг бүрэн хэрэгжүүлэгч орон гэдэг утгаар оролцож байгаа тул бид нилээн сайн бүрэлдэхүүнтэй оролцох ёстой, асуултанд хариулах чадвартай хүмүүс очих ёстой, санаачилгыг цаашид хөгжүүлэхэд нэмэр

болох шинэ санаа олж авахуйц ийм бүрэлдэхүүнтэй оролцох ёстой. Тийм учраас зарчимаа тохироод авбал яасан юм гэсэн саналтай байна.

Н.Алгаа: Долгор даргын саналтай нэг байна. Үндэсний зөвлөл болон ажлын хэсгийн гишүүн иргэний нийгмийн байгууллагуудаас явах нь зөв гэж үзэж байна.

Н.Дорждарь: Иргэний нийгмийн байгууллагаас хэн явахыг ажлын хэсэг биш, иргэний нийгмийн байгууллага өөрсдөө шийдэх нь зөв гэсэн зарчмын саналтай байна. Зохион байгуулалтыг бид хийхэд бэлэн байна.

Б.Долгор: Цаанаас зардлаа даалгуулаад явах иргэний нийгмийн төлөөллийг сонгохдоо оролцоог нь дүгнээд шийдэх нь зөв, сонгон шалгаруулаад байх шаардлага байхгүй гэж бодож байна. Харин нийслэлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Адъяагийн зардлыг нийслэлээс гаргуулах талаар санал тавья. Бусдаар бол санал болгож буй бүрэлдэхүүнийг дэмжиж байна гэж ойлгох уу?

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг нэгтгэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг тогтож, Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэхийг Ажлын алба (Ш.Цолмон) –д даалгав.

Б.Долгор: За бид хэлэлцэх асуудлаа дууслаа. Афганистан Улсын төлөөлөгчид манай өнөөдрийн хуралдаанд оролцож байгаа гэж хурлын эхэнд хэлсэн. Бидний хувьд манай улсын туршлагыг судлахаар ирсэнд баяртай байгаа бөгөөд тодорхой хэмжээний туршлага олж авсан байх гэж найдаж байна. Ингээд та бүхэнд биднээс асуулт байвал асууж болно, мөн санал сэтгэгдлээ хуваалцахыг урьж байна.

Зохицуулагч Башир Хан: Сайн байцгаана уу. Монгол Улс ОУИТБС-ыг бүрэн хэрэгжүүлэгч орны хувьд өөрсдийн мэдлэг, туршлагаас суралцах боломж олгосонд Афганистан Улсын ОУИТБС-ын ажлын хэсэг, ажлын албаны нэрийн өмнөөс гүнээ талархаж байна.

Цаашид ч бид танай орноос илүү их зүйл суралцахыг хүсч байна. Харамсалтай нь 12 дугаар сарын 5-ны өдөр бид ажлын хэсгийн хуралтай тул маргааш өглөө эх орондоо буцна. Өнгөрсөн хэд хоног бидний хувьд маш их зүйлийг суралцсан, өдөр бүхэн шинэ зүйлийг мэдэрсэн гайхалтай мөч байлаа. Өнөөдөр ч гэсэн та бүхний ажлын хэсгийн хуралдаанаас өмнө нь асуухыг хүсч байсан зүйлүүддээ хариулт олж авч, та бүхэн асуудлыг хэрхэн өөр өөр замаар шийдэж буйг, асуудлыг хэрхэн хоорондоо ярилцаж хэлэлцэж байгааг, гишүүд хэрхэн идэвхтэй оролцож буйг өөрийн биеэр мэдэрсэндээ маш их баяртай байна. Биднийг маш найрсаг дотноор угтан авсан монголын төр засаг, ард иргэд, санаачлагын хамт олонд бүгдэд нь дахин талархсанаа илэрхийлмээр байна.

Б.Долгор: За баярлалаа. Манай улсын хувьд богино хугацаанд санаачлагыг бүрэн хэрэгжүүлэгч орон болсон нь гурван тал маань тэгш оролцож, маш идэвх зүтгэлтэй ажилласны үр дүн гэж ойлгож байна. Ингээд та нөхдөд ч бас санаачлагыг бүрэн хэрэгжүүлэгч орон болохын төлөө идэвх зүтгэлтэй ажиллахыг хүсэн ерөөхийн ялдамд Афганистан Улсын хөгжилд амжилт хүсч байна.

Төлөөлөгч: Баярлалаа.

Б.Долгор: Хурлын төгсгөлд амжилттай ажилласан хүмүүстээ шагнал гардуулах үйл ажиллагааг эхлээ. Ажлын хэсгийн гишүүн Н.Дорждарь, Н.Алгаа, Татварын ерөнхий газарт Ерөнхий сайд, ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн даргын өргөмжлөл гардуулав.

Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа мөн ажлын хэсгийн үйл ажиллагаанд идэвх чармайлт гарган ажиллаж буй бүх гишүүдэд, тэр дундаа өнөөдрийн хүндтэй шагналыг хүртсэн байгууллага, хамт олон, гишүүддээ баяр хүргэж улам их амжилтыг хүсэн ерөөе.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа бүрэн шийдвэрлэсэн тул өндөрлөө.

Ажлын хэсгийн хурал 18 цаг 00 минутад дуусав.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Ажлын хэсгийн ахлагч



Б.ДОЛГОР

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн



Б.ДЭЛГЭРМАА